

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГАЛЬ, ОРЧНЫГ
ХАМГААЛАХ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар /цаашид Хэлэлцэн тохирогч хоёр Тал гэж нэрлэх/ 1960 онд байгуулсан Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай Гэрээний үзэл санааг үндэс болгон Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд 1988 онд байгуулсан Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс хоёр орны хамтын ажиллагааг байгаль, орчныг хамгаалах салбарт хөгжүүлэх зорилгоор дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр байгаль, орчныг хамгаалах салбарт хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлнэ.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал дараах чиглэлээр хамтран ажиллана:

-элсний нүүлт, хөрсний элэгдэл, эвдрэлийг зогсоох технологи, арга зүйг судлан хэрэгжүүлэх;

-говийн бүсэд мод, бут, сөөг, бусад ургамлыг тарих, ургуулах, хортон устгах технологи, арга зүйг судлан хэрэгжүүлэх;

-говь, хээрийн бэлчээрийг хамтран судалж, түүнийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээ боловсруулах;

-хил залгаа нутагт цагаан зээр болон бусад зэрлэг ан амьтан, ургамлыг хамгаалах, судлах, үржүүлэх болон зохистойгоор ашиглах арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх;

-байгаль, орчны болон ялангуяа хил залгаа нутгийн агаар, ус, хөрсний бохирдлыг судлах, хянах, урьдчилан сэргийлэх, багасгах, арилгах, гадаргын усны нөөцийн хомсдлыг зогсоох технологи, арга зүйг судалж боловсруулах;

-хил залгаа нутагт байгаль хамгаалах, дархалсан болон ан агнахыг хориглосон бүсийг хоёр Тал хамтран бий болгох, эдгээр бүсэд явуулах шалгалт, судалгаа, туршилтын ажлыг харилцан зохицуулж, зохион байгуулах;

-мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэгчдийг сургах талаар хамтран ажиллах;

-төлөвлөгөө, төсөл боловсруулан хэрэгжүүлж, байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хамтран өгөх, байгаль хамгаалах суурь болон хавсарга шинжилгээ, судалгааг хамтран явуулах;

-Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллага, Засгийн газрын бус байгуулагчын хүрээнд байгаль, орчныг хамгаалах асуудлаар үйл ажиллагаагаа зохицуулах, хамтран ажиллах;

-хил залгаа орон нутгийн байгаль, орчныг хамгаалах байгууллагуудын хооронд хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлэх.

Гүрвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасан хамтын ажиллагааг Хэлэлцэн тохирогч хоёр Тал дараах замаар хэрэгжүүлнэ:

-шаардлага, боломжийг харгалзан шинжилгээ судалгаа, туршилтын ажлын хамтарсан төв, лаборатори болон мэргэжилтний хэсэг байгуулах асуудлыг авч үзэх;

-байгаль, орчныг хамгаалах, хянах асуудлаар ном хэвлэл, техникийн баримт бичиг, зураг төсөл, мэдээлэл харилцан солилцох;

-байгаль, орчныг хамгаалах, хянах асуудлаар эрдэм шинжилгээний бага хурал зохиох;

-байгаль, орчныг хамгаалах, хянах асуудлын төлөвлөлт болон үйл ажиллагааны туршлага судлах талаар эрдэмтэн, мэргэжилтэн харилцан солилцож шинжлэх ухаан-техникийн сэдвээр ажиллахад туслалцаа үзүүлэх.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Хэлэлцээрийн зорилгын үүднээс хоёр улсын холбогдох яам, улсын хороо, байгууллагуудын хооронд байгаль, орчныг хамгаалах салбарт хамтын ажиллагаа тогтоохыг дэмжинэ.

Тавдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийг БНМАУ-ын талаас Байгаль, орчныг хамгаалах Яам, БНХАУ-ын талаас Байгаль, орчныг хамгаалах газар хэрэгжүүлнэ.

Зургалугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын холбогдох байгууллагын төлөөлөгчид, мэргэжилтний уулзалтыг харилцан тохиролцсон хугацаанд хийж хамтын ажиллагааны төлөвлөгөө, ажиллах чиглэл болон хамтын ажиллагааны нөхцөлийн талаар тохиролцож байна.

Долгугаар зүйл

Төлөөлөгчид, мэргэжилтний очих, буцах замын зардлыг илгээгч Тал, тэдний ажиллах хугацааны байр, хоол, дотоодын тээврийн зардлыг хүлээн авагч Тал тус тус хариуцна.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд явуулсан хамтын ажиллагааны үр дүн, нөгөө Талаас авсан мэдээлэл, техникийн баримт бичгийг Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрсдийн нутаг дэвсгэр дээр ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ашиглана. Харин тэдгээрийг аль нэг Тал нь нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр гуравдахь этгээдэд дамжуулах буюу илээр нийтлэх ёсгүй.

Еслүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн аль нэгэн заалт Хэлэлцэн тохирогч хоёр Талын хооронд буюу аль нэг Талаас гуравдахь этгээдтэй байгуулсан Гэрээ, Хэлэлцээрээр авсан үүргийг үл хөндөнө.

Аравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал тохиролцох замаар энэхүү Хэлэлцээрт өөрчлөлт, нэмэлт оруулж болно.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд таван жилийн хугацаатай байна.

Хэрэв Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэг нь нөгөө Талдаа энэхүү Хэлэлцээрийн хугацаа дуусахаас 6 сарын өмнө түүнийг цуцлах саналаа бичгээр мэдэгдээгүй бол хүчинтэй байх хугацаа нь тав таван жилээр сунгагдаж байна.

Энэхүү Хэлэлцээрийг цуцалсан ч хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж дуусгана.

Энэхүү Хэлэлцээрийг Бээжин хотноо 1990 оны тавдугаар сарын 6-ны өдөр монгол, хятад хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС



钱其琛